



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2015 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

"Төрийн албаны зөвлөлийн хуралдааны дэг"-д  
нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 35.1.3, Улсын Их Хурлын 2009 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 1.4, 4.1, 4.2-т тус тус заасныг үндэслэн, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 4 дүгээр хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Төрийн албаны зөвлөлийн хуралдааны дэг"-ийн 2.7, 3.1 дэх заалтад дор дурдсан нэмэлтийг тус тус оруулсугай.
  - а. 2.7-д "Зөвлөлийн гишүүн албан ажлын шаардлагаар өөрийн биеэр хуралдаанд оролцох боломжгүй зайлшгүй нөхцөл үүссэн тохиолдолд саналыг нь бичгээр авч болно. Гишүүн нь "Хуралдааны дэг"-ийн 3.5-д заасны дагуу хэлэлцэх асуудал тус бүрээр саналаа илэрхийлж, тайлбарын хамт ирүүлнэ. Бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн, хуралдааны ирцэд тоолж, санал өгсөнд тооцно" гэж нэмэлт оруулах,
  - б. 3.1-д "Зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд Хуралдаанд заавал оролцоно. Хүндэтгэн үзэх шалтгаанд өвчтэй байх буюу өвчтэй хүн асарсан, эсхүл гадаад буюу орон нутагт томилолтоор явсныг тооцно" гэж нэмэлт оруулах.
2. Хуралдааны дэгийг Зөвлөлийн гишүүд, Ажлын албаны холбогдох хүмүүст танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ажлын албаны дарга /С.Цэдэндамба/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦОГОО